

**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 04 дүгээр сарын
14-ны өдөр

№ ХЭХ 03/01

Улаанбаатар
хот

**“Жуулчин Дюти фрий” ХК-ийн 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
тэмдэглэл.**

2023 оны 04 сарын 14-ны өдөр 16:00 минут, Баасан гараг, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Элчингийн гудамж, Жуулчин ХХК-ийн байрны, 2 дугаар давхрын хурлын танхимд хуралдав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Сайн байцгаана уу. Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг ХЭХ материалд оруулсан байгаа. Энэ дэгийн дагуу өнөөдрийн хурал зохион байгуулагдана. Хурлыг дэгийг дэлгэрэнгүй байдлаар хурлын дарга хурлыг нээж үг хэлсний дараа танилцуулъя.

Одоо хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу хурлын ирц бүртгэлийн талаар тооллогын комиссын дарга Б.Намуундарь танилцуулна.

Тооллогын комиссын дарга Б.Намуундарь: Сайн байцгаана уу. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн танилцуулъя.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит энэ хуралд 9 хувьцаа эзэмшигч биеэр оролцож, нийт саналын эрх бүхий нийт хувьцааны 79,21 хувь болж байгааг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигч нар болон хурлын даргад мэдээлсүгэй. Ингэснээр хурлыг хүчин төгөлдөрт тооцож хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг үргэлжлүүлэхэд ирц хүрсэн байна.

Тооллогын комиссоос гарч буй Хурлын ирцийн тогтоолыг танилцуулав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц хүчин төгөлдөр болсон байна. Тооллогын комиссоос тогтоол гарсантай та бүхэн танилцлаа.

Энэхүү хурлыг нээж үг хэлнэ үү гэж хурлын дарга компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээс хүсье.

Хурлын дарга, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаяр: Сайн байцгаана уу та бүхний энэ өдрийн мэнд хүргэе. Хурлын хүрээнд нийт 7 асуудлыг хэлэлцэхээр байна. Тооллогын комиссын даргын танилцуулснаар хурлын ирц бүрдсэн тул хурлыг эхлүүлье.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ:

Ц.Отгонбаяр захиралд баярлалаа. Хурлыг нээж үг хэллээ. Ингээд хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн 2023 оны 04 сарын 14-ны өдрийн хурлын даргаар Ц.Отгонбаяр захирал ажиллаж байгаа. Хурлаар хэлэлцэх асуудал.

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах /Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаяр/
2. ТУЗ-аас санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг хэлэлцэх, батлах, /Ерөнхий нягтлан бодогч Б.Алтанцэцэг/
3. Компанийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг танилцуулах /Ерөнхий нягтлан бодогч Б.Алтанцэцэг/

4. Компанийн 2022 оны ногдол ашгийн тухай гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ/
5. Компанийн 2023 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг танилцуулах, батлах /Ерөнхий нягтлан бодогч Б.Алтанцэцэг/
6. "Жуулчин Дютри Фрий" Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон хэлбэрийг өөрчлөх талаар танилцуулах /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ/
7. Компанийг өөрчлөх төслийг танилцуулж, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг шинэчилж батлах /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ/

гэх 7 асуудлыг энэхүү хурлаар хэлэлцэнэ. Та бүхэнд хүргүүлсэн хурлын материалд дээрх 7 асуудлыг тодорхой тусгасан байгаа.

Үүний дараа асуулт, хариулт байна. Асуулт байвал тухай бүр нь тодруулаад явахыг хүсье.

Цаашлаад хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулах, санал хураалтын дүнг танилцуулах, хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах, батлах, хурлыг хаах дарааллаар хурал үргэлжилнэ.

Хурлын дэгийг танилцуулж дуусав.

Өнөөдрийн хуралд Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг миний бие ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ танилцуулна.

Үйл ажиллагааны тайлан нь компанийн танилцуулга бүтэц, зохион байгуулалт салбар дэлгүүрүүдийн мэдээлэл, татан авалтын мэдээлэл, хувьцааны мэдээлэл, санхүүгийн үзүүлэлт, компанийн хэлбэрийн өөрчлөлт гэх үндсэн агуулгын хүрээнд яригдана.

2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2023 оны зорилтуудын талаар Компанийн тухай хууль, "Жуулчин Дютри Фрий" ХК-ийн дүрмийн хүрээнд ТУЗ-ийн хурлаар хэлэлцлээ. "Жуулчин Дютри Фрий" ХК-ийн 2016 оны 07 сард тус компанийн хяналтын багцын хувьцааг худалдан авсан бөгөөд үүнээс хойших хугацаанд тус компанийн үйл ажиллагааг амжилттай үргэлжлүүлэн ажиллуулжээ.

Та бүхний мэдэж байгаачлан Ковидоос шалтгаалан сүүлийн 3 жил үйл ажиллагаа явуулаагүй. Үндсэн үйл ажиллагааны хувьд Татваргүй барааны дэлгүүрийн тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагааг явуулдаг.

2020 оны 09 сард томилогдсон ТУЗ өнөөг хүртэл хэвээр үйл ажиллагааг явуулж байна. ТУЗ-ийн ердийн гишүүдийг танилцуулав. Хараат бус гишүүдийн хувьд 3 байсан боловч Пүрвээ хараат бус гишүүн маань нас барсан учир одоогоор 2 гишүүнтэйгээр ТУЗ маань үйл ажиллагаагаа явуулж байна.

Татваргүй барааны дэлгүүрийн 21 жилийн туршлагатай. 3 салбар дэлгүүртэйгээр үйл ажиллаж байгаад Хөшигтийн Хөндийд байрлах шинэ нисэх буудал ашиглалтад орсонтой холбогдуулан үйл ажиллагаагаа зогсоосон. Одоогоор 2 салбар дэлгүүртэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

ТУЗ нь Эрсдэл, Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын гэсэн 3 хороодтой. Компанийн бүтцийн хувьд өмнөх оныхоос өөрчлөлт орсон зүйл байхгүй.

Салбар дэлгүүрүүдийн хувьд:

1-р салбар Төмөр замын дэлгүүрийн татваргүй барааны дэлгүүр нь вокзалын 2 дугаар давхарт байрладаг, гаалийн хяналтын доор үйл ажиллагаа явуулдаг. 2020 оны 3 сараас хойш үйл ажиллагаа явуулаагүй. Тусгай зөвшөөрөл гарсан байгаа боловч Гаалиас нээх зөвшөөрөл олгохгүй байсаар өнөөдрийг хүртэл үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.

2-р салбар Алтанбулаг шалган нэвтрүүлэх төвийн 1-р давхарт байрлан 46,7 м2 талбайтай үйл ажиллагаа явуулж байсан боловч Алтанбулаг хилийн боомт маань засварын ажил хийгдэхтэй холбоотой хилийн шалган нэвтрүүлэх байрыг бүр мөсөн буулгах болсон тул бид талбайг чөлөөлж өгөхөөр болсон. Талбай чөлөөлөхтэй холбоотой бид өөрсдийн барааг түр гаалийн бүсэд контейнерт хадгалж байсан. 2022 оны 4 сараас эхлэн хойд хил нээх болсон, хөдөлгөөн хэвийн үргэлжлэх болсонтой холбоотойгоор бид Гаалийн байгууллагад хүсэлт өгсөөр 8 сараас эхлэн гаалийн бүсийн гадаа түр зөөврийн сууцанд үйл ажиллагаа явуулж байна. Түр, зөөврийн орон сууц гэдэг нь бид өөрсдийн зардлаар зөөврийн орон сууц шиг загвартай дэлгүүрийн захиалгаар хийлгэн Сэлэнгийн гаалиас зөвшөөрөл авч гаалийн бүсэд гадаа талбай дээр зөөврийн дэлгүүрээ түр байршуулан үйл ажиллагаа явуулах боломжтой болсон тул ийм арга замаар дэлгүүрээ 8 дугаар сараас эхлэн хэвийн горимд шилжүүлэн ажиллаж байна. Мөн тухайн өр орчмын тохижилтын өөрсдийн зардлаар засварлаж гааль болон хил, шалган гэх мэт төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Дэлгүүрийн бараа татан авалт бол хамгийн сүүлийнх нь 2020 оны 02 сард татан авсан. Эдгээр бараанаас зарим нь Алтанбулаг салбар дээр зарагдаж байна. Харин зарим хэсэг нь Төмөр зам салбарт гаалийн байгууллагын хяналтын доор лацадсан, борлуулах боломжгүй байдалтай байгаа. Одоо дахин татан авалтыг гадаадаас хийхээр төлөвлөж ажиллаж байна.

Өмнө дурдсанчлан Таван Богд Трейд ХХК нь компанийн 70,92 хувийг, Радар Фанд ХХК, Куритар Партнерс ХХК нар хамтдаа 8 хувийг эзэмшиж байна. Үлдсэн ойролцоогоор 29,8 хувь нь жижиг хувьцаа эзэмшигч нар байна. 3 сарын 24-ны байдлаар тархалтын мэдээ авахад 352 ширхэг жижиг хувьцаа эзэмшигч байна гэж гарч ирсэн.

2023 оны 01 сараас хойш манай компанийн хувьцааны арилжаа Хөрөнгийн бирж дээр идэвхэжсэн бөгөөд 30-40 хувьцаа эзэмшигчид маань хувьцаагаа зарж компаниас гарсан байна. 2020, 2021 онд Ногдол ашиг тараагаагүй. Учир нь Ковидын он жилүүдээс шалтгаалж үйл ажиллагаа явуулаагүй тул олгоогүй. 2022 онд Үндсэн үйл ажиллагаа алдагдалтай ажилласан тул ТУЗ-с 2022 онд ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн байна.

Бид үйл ажиллагаатай холбоотой тархалтын мэдээг 2023 оны 03 дугаар сарын 31-ны байдлаар ҮЦТХТ-с авахад нэгж хувьцаа 66,600 төгрөгийн ханштай байна.

ТУЗ-ийн үйл ажиллагаа бол 2020 онд сонгогдсоноос хойш компанийн үйл ажиллагаа зогссон нөхцөл байдлаас шалтгаалан ТУЗ-ийн гишүүд цалин хөлс олгогдоогүй, зогсоосон бөгөөд өнөөдрийн байдлаар энэ нөхцөл байдал хэвээр байна. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон ерөнхий нягтлан болдогч нар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжиж ажиллаж байна. Мөн сул зогсолттой буюу төмөр замын салбар дэлгүүрийн 2 ажилтан мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжиж байгаа. Учир нь бид ажлын байрыг хадгалах үүднээс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулж байна.

Үйл ажиллагаатай холбоотой тайланг танилцуулж дууслаа.

2022 оны санхүүгийн тайлан, 2023 оны төсвийг болон Хөндлөнгийн аудитын дүгнэлт болон ТУЗ-ийн дүгнэлтийг компанийн ерөнхий нягтлан бодогч Б.Алтанцэцэг танилцуулна.

Ерөнхий нягтлан бодогч Б.Алтанцэцэг:

Бүгдэд нь оройн мэнд хүргэе. "Жуулчин Дютри Фрий" ХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг танилцуулъя.

"Жуулчин Дютри Фрий" ХК нь коюидоос шалтгаалан 2022 оны 08 сараас эхлэн үндсэн үйл ажиллагаа эхэлж, Алтанбулаг салбар үйл ажиллагаа явуулж байна. 2022 оны эхэнд компанийн нийт хөрөнгийн хэмжээ 3,2 тэрбум байсан нь 3,6 тэрбум болж өссөн байгаа.

Энэ өсөлт нь Алтанбулаг боомт дээр түр, зөөврийн сууц бариулсан мөн эргэлтийн хөрөнгө маань 266 саяар өссөн байгаа. Ногдол ашгийн өглөгийн хувьд оны эхэнд 999 сая төгрөгийн өглөгтэй байсан бол оны эцэс гэхэд 977 сая болж буурсан байна. Хуримтлагдсан ашиг маань 2,2 тэрбум байсан бол оны сүүлд 2,5 тэрбум болж өссөн харагдаж байна.

Орлогын хувьд нийт ашиг маань 191 сая байснаас үйл ажиллагааны зардалд 236 сая төгрөгийн, 5 сая төгрөгийн бусад орлого, 963 мянган төгрөгийн бусад зардалтайгаар нийт 398 сая төгрөгийн ашигтай харагдаж байгаа.

Ингээд 320 сая төгрөгийн ашигтай харагдаж байгаа нь бид сул мөнгөө толгой компаниас 2,4 тэрбум төгрөгийн авлагатай байгаа бөгөөд сул мөнгө маань валютаар хадгалагддаг тул ханшийн зөрүүнээс нийт 397 сая төгрөгийн олз хүлээсэнтэй холбоотой байна. Үндсэн үйл ажиллагаанаас бол 77 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бид 2 салбараа нээж ажиллуулна гэсэн төлөвлөгөөтэй байсан боловч төрийн байгууллагын шийдвэрээс шалтгаалан одоогоор нэг салбар маань л ажиллаж байна.

Бид 2023 ондоо 2,5 тэрбумын борлуулалтын орлого хийж, 579 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн байна.

Хөндлөнгийн аудитын дүгнэлтийн хувьд бид 2022 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгон "Шинэ Их Тэрбум" гэх аудитын компаниар аудит хийлгэсэн.

Өмнөх аудит маань 5 жилийн хугацаа өнгөрсөн тул шинэ аудит оруулсан байгаа. 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр гарсан аудитын тайланд ямар нэгэн зөрчил, зөвлөмж одоогийн байдлаар гараагүй хөндлөнгийн аудитын дүгнэлт гарсан байна.

Хувьцаа эзэмшигч Д.Баатаржав: Одоо байгаа гол авлага маань бусад авлага л байгаад байна. 2021, 2022 онуудад энэ авалтын дүн өсөөгүй харагдаад байна. Миний ойлгож байгаагаар тодорхой хүүтэйгээр зээлж байгаа гэж ойлгож байгаа. 2022 онд валютын ханшийн зөрүүнээс шалтгаалан 20 хувийн ашиг олсон юм шиг байна. 2021 онд мөнгөн хөрөнгө маань яагаад өсөөгүй вэ?

Ерөнхий нягтлан Б.Алтанцэцэг: Тухайн үед валютаар хийж байгаа гүйлгээ учраас хүүтэй байх талаар талууд тохиролцоогүй мөн ковидоос шалтгаалан хүү тооцоогүй байгаа.

Хувьцаа эзэмшигч А.Жавхлан: Санхүүгийн төлөвлөгөөн дээр 280 сая төгрөгийн борлуулалт, маркетингийн зардал гэж тусгасан байна. Үүнд юу хамаарч байгаа вэ?

Ерөнхий нягтлан Б.Алтанцэцэг: Энэхүү зардалд борлуулалт маркетинг ерөнхий удирдлагын зардал хамаарч байгаа. Жилдээ урсгал зардалд 280 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

Хувьцаа эзэмшигч Д.Баатаржав: Одоогоор хэдэн ажилтантай байгаа вэ?

Ерөнхий нягтлан Б.Алтанцэцэг: Одоогийн байдлаар 8 ажилтан ажиллаж байгаа. 2 худалдааны зөвлөх маань сул зогсолтоор цалинжиж байгаа, хүний нөөцийн менежер, хуулийн зөвлөх 2 маань хавсарсан ажлын байрны цалингаар цалинжин ажиллаж байна.

Хурлын дарга, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаяр: Шинэ үйл ажиллагааны менежерийг бид 04 дүгээр сарын 10-аас эхлэн ажиллуулж эхлүүлсэн. Өмнө нь миний бие хавсран ажиллаж байсан.

Хувьцаа эзэмшигч Д.Баатаржав: 2020 онд 212 сая байж байгаад 2021 онд 133 сая болж буурсан байна энэ талаар тодруулга өгөөч.

Ерөнхий нягтлан Б.Алтанцэцэг: Бид үйл ажиллагааны зардал өндөр гарсантай холбогдуулан элэгдлийн зардлыг буруулах зорилгоор нэг автомашин байсныг зарж борлуулсан.

Хувьцаа эзэмшигч Ж.Энхтунгалаг: Үндсэн хөрөнгө гэдэгт энэ байр орж байгаа юу? Яг үндсэн байр чинь хаана байрлаж байна вэ?

Ерөнхий нягтлан Б.Алтанцэцэг: Одоо хурал хийж буй газар маань “Жуулчин” компанийн өмч байгаа үйл ажиллагааныхаа зардлыг хэмнэх зорилгоор түрээсийн байрыг бид ашиглаж байна. Оффисын үндсэн хөрөнгө байхгүй бусад хэрэглээний үндсэн хөрөнгүүд байгаа.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Манай үндсэн байршил бол ХУД–т байрлах Таван Богд компанийн байр байдаг. Бид өмнө нь Гоёо дээр түрээс төлж байрладаг байсан. Тухайн үед Гоёо ХХК-ийг түрээсэлж байсан.

Хурлын дарга, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаяр: Бид өмнө нь Гоёо компанийн оффис дээр 3, 4 өрөө түрээсэлж суудаг байж байгаад ковидоос шалтгаалан үйл ажиллагаа доголдсон тул зардлаа хэмнэхийн тулд түрээсээ багасгаад 2022 оны 09 сараас эхлэн энэ байранд нэг өрөөг 1,5 сая төгрөгийн түрээсийн төлбөртэйгөөр үйл ажиллагаа явуулж байна.

А.Жавхлан: Тэр түрээсийн зардалдаа 41,7 сая төгрөг төсөвлөсөн байгаа юу?

Ерөнхий нягтлан Б.Алтанцэцэг: Энэ маань салбар дэлгүүрүүдийн маань түрээсийн зардал хамаарч байгаа. Вокзалын салбар дээр нэмэлтээр мэдээлэл өгөхөд Бид үйл ажиллагаа явуулаагүй хэдий ч Төмөр замын Төв буудлын тавьсан шаардлагын дагуу талбайгаа хадгалж үлдэх зорилгоор түрээсийн төлбөрийг урт хугацаанд буюу ажиллагаагүй хугацааныхыг төлж байгаа. Ерөнхий удирдлага дээр байгаа түрээсийн зардал нь бол оффисын түрээсийн зардал байгаа.

Хувьцаа эзэмшигч Д.Баатаржав: Одоо байгаа 216 сая төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгө нь ямар гол хөрөнгүүд байгаа вэ?

Ерөнхий нягтлан Б.Алтанцэцэг: Дэлгүүрүүд дээр хэрэглэгдэж буй тавилга эд хогшлууд, зөөврийн сууц, Prius -30 маркийн автомашин байгаа. Зөөврийн сууцын хувьд 8*8 хэмжээтэй, шалнаасаа халдаг, 2 салгаж зөөх боломжтой сууц байгаа. Түрүүн тайлан дээр дурдсанчлан Алтанбулаг салбарыг нээхийн тулд захиалгаар хийлгэсэн сууц байгаа.

Хурлын дарга, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаяр: Алтанбулагийн салбарын хувьд Гаалийн төв байр маань нурсан, шинэ барилга маань 2023 онд ашиглалтад орох байсан боловч одоогоор баригдаж эхлээгүй байгаа. Иймд бидний зүгээс Гаалийн бүсэд үйл ажиллагаа явуулахаар удаа дараа хүсэлтээ өгч 5 сарын дараа хүсэлтийг шийдвэрлэн зөөврийн сууцанд үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Өмнө манай компани 3 автомашинтайгаар үйл ажиллагаа явуулдаг байсан. Энэ нь Нисэх болон Алтанбулаг салбар руу явах, тооллого хийх зэрэгт шаардлагатай байсан. Гэвч бид одоогоор зөвхөн Алтанбулаг салбарт үйл ажиллагаа явуулж байгаа учир 2 автомашин хангалттай, энэ нь хувьцаа эзэмшигчдэд илүү үр өгөөжтэй гэж үзээд нэг автомашинаа зарсан байгаа.

Хувьцаа эзэмшигч Д.Баатаржав: Санхүүгийн аудитын тайлан цахим хэлбэрээр бүтнээр нь орох ёстой боловч цахимаас үзэхэд дүгнэлт 3 хуудас байна. Үүнийг бүтнээр нь одоо үзэж болох уу?

Ерөнхий нягтлан Б.Алтанцэцэг: Боломжтой. Та хурлын дараагаар надтай уулзаад аваарай.

Хувьцаа эзэмшигч Ж.Энхтунгалаг: Гол хувьцаа эзэмшигч "Таван Богд Трейд" ХХК нь Жуулчны бааз худалдан авч байгаа талаар мэдээлэл авсан. Энэ талаар тодруулаач.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Тэр хувийн жуулчны баазтай болж буй компани маань бол Жуулчин ХХК гэдэг тусдаа компани байгаа. "Жуулчин Дюти Фрий" ХК маань бол үндсэн үйл ажиллагаа татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа явуулдаг.

Хувьцаа эзэмшигч Д.Баатаржав: ТУЗ-ийн гишүүд дээр цалин урамшуулал байгаа юу? Хараат бус гишүүдээ хэрхэн сонгож байгаа вэ?

Ерөнхий нягтлан Б.Алтанцэцэг: ТУЗ-ийн гишүүдийн хувьд цалин хөлс байхгүй. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга маань хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжиж байгаа.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: 2020 оны 9 дүгээр сард компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар ТУЗ-ийн хараат бус гишүүдийг нээлттэй байдлаар сонгон шалгаруулсан. Өмнөх бүрэлдэхүүнд ажиллаж байсан 2 гишүүн маань дахин хүсэлт гарган орж ирээд, 3 хүн шинээр материал ирүүлж горилоод, нийт 5 кандидаттаас ээлжит бус хурлаар энгийн болон хараат бус гишүүдийг сонгосон байна.

Өөр санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, аудитын дүгнэлттэй холбоотой асуулт байхгүй бол дараагийн асуудал буюу компанийн хэлбэрийг өөрчлөх талаар хэлэлцье.

Компанийн тухай хуульд заасны дагуу Хувьцаа эзэмшигч нь ХЭХ-д хэлэлцэх асуудалд саналаа ирүүлэх эрхтэй байдаг. Үүний дагуу "Таван Богд Трейд" ХХК-иас Компанийн хэлбэрийг өөрчилж ХХК болох асуудлыг хэлэлцье гэх саналыг ТУЗ-д ирүүлснийг ТУЗ-өөс энэхүү саналыг хүлээн авч, ХЭХ-д оруулж ирсэн байгаа.

"Таван Богд Трейд" ХХК-ийн зүгээс компанийн үйл ажиллагаа сүүлийн 3 жил доголдолтой байна. Гуравдагч этгээдийн буруутай үйлдэл, үйл ажиллагаа болон төрөөс мөн компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх шийдвэрүүдийг гаргасаар байгааг харгалзан үзэж энэхүү саналыг ТУЗ-д оруулсан. Төрийн шийдвэр гэдэг нь компанийн хувьд Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхэлдэг энэ нь ГЕГ-аас олгодог тусгай зөвшөөрлийн үндсэн дээр явуулдаг үйл ажиллагаа юм.

ГЕГ-аас энэ оны 03 дугаар сард манай компанийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох агуулга бүхий албан бичиг ирсэн. Энэхүү албан бичиг нь 2 үндэслэлтэй. Үүнд нэгдүгээр 2017 оноос хойш өнөөдрийг хүртэл үйл ажиллагаа явуулахдаа Гаалийн бүсэд нийт 8 зөрчил гаргасан, 2 дугаарт 2017 онд Таван Богд Трейд хяналтын багцыг худалдан аваад компанийн нэрийг үндсэн үйл ажиллагаатай уялдуулан "Жуулчин Дюти Фрий" болгон өөрчилснийг ГЕГ-аас дүгнэхдээ Тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн гэх агуулгаар тушаал гаргасан бөгөөд энэ нь хууль зөрчсөн үйлдэл болсон.

ГЕГ-аас эдгээр нөхцөл байдлыг шалган тогтоогоод хүчингүй болгох тухай мэдэгдлийг бидэнд хүргүүлсэн. Бидний зүгээс буцаан ГЕГ-т хариу тайлбарыг үйл ажиллагаа, компани хэвээрээ байхад ийнхүү шилжүүлсэн шийдвэр гаргасан нь хууль бус, мөн нэгэнт бид зөрчлүүдэд хариуцлага хүлээсэн байхад компанийн болон 300 гаруй хувьцаа эзэмшигчдийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг хохироож буй нь үндэслэлгүй талаар хүргүүлсэн байгаа.

Бид татваргүй барааны тусгай зөвшөөрлүүдээ ГЕГ-т 2022 оны 10, 11 сард хүсэлт гаргаж татваргүй барааны тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацааг 3 жилээр сунгуулан авч чадсан. Гэтэл 2022 оны 12 сард татваргүй барааны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан атал он гараад 3 сард бидэнд тусгай зөвшөөрлийг цуулах талаар мэдэгдэл ирснийг бид бүхэн бас гайхаж байгаа. Төрийн байгууллагаас ямар учир шалтгаанаар энэ асуудал хөндөгдөж байна гэх мэт.

Иймд "Таван Богд Трейд" ХХК-ийн зүгээс компанийн үндсэн үйл ажиллагаа зогсох хүртэл эрсдэл үүсэх боломжтой байгаа учир 350 гаруй хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор, эрсдэлийг дангаар хүлээх зорилгоор ХХК болгон өөрчлөх саналыг ТУЗ-д оруулж, ТУЗ тогтоол гарган энэхүү ХЭХ хуралдаж байна.

Хувьцаа эзэмшигч Д.Баатаржав: ХК байх тусмаа төрийн хамгаалалт авах ёстой биш үү?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: ГЕГ-ын удирдлага солигдсонтой холбогдуулан бидэнд ХК байгаагийнхаа төлөө ямар нэгэн ашигтай, хэрэгтэй нөхцөл байдал үүсэхгүй байна. Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд дунд манайх ганцаараа ХК боловч бусад компаниудтай адил төрийн бодлогын, шийдвэрийн хор уршиг үүссээр байгаа юм.

Бид компанийн үйл ажиллагааг хэвийн явуулахыг эрмэлзэж байгаа боловч төрийн байгууллагын шийдвэрийн улмаас үйл ажиллагаа зогсох хүртэл хэмжээний эрсдэл үүсээд байгаа юм. Иймд компанийг хэрхэн хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах талаар бодлого хэрэгжүүлж байгаагийн нэг хэсэг ХХК болгох асуудал юм.

Хувьцаа эзэмшигч Ж.Энхтунгалаг: Төрөөс үзүүлж буй дарамтыг шийдвэрлэх зорилгоор хуулийн байгууллагад хандсан зүйл байгаа юу?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Одоогийн байдлаар манай тусгай зөвшөөрлийг шууд хүчингүй болгосон асуудал байхгүй, хүчингүй болгох гэж байна шүү гэсэн агуулгатай мэдэгдэл өгсөн байгаа. Иймд бидний зүгээс хуулийн хүрээнд хариу тайлбарыг өгсөн. Шууд шүүхэд өгөх хэмжээний асуудал үүсээгүй байна.

Хувьцаа эзэмшигч Д.Баатаржав: Группийн зүгээс энэ бизнесийг өргөжүүлэхээр байгаа юу?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Шинэ Нисэх баригдаж эхлэхэд бидний зүгээс зарласан тендерт өрсөлдсөн боловч сонгон шалгараагүй ялагдсан. Энэ асуудлаар шүүхэд хандсан боловч мөн манай нөгөө талд шийдсэн асуудал бол байгаа. Гэвч бид дахин тендер зарлагдвал мэдээж өрсөлдөх болно. Мөн бид Замын үүдийн чөлөөт бүс, Алтанбулаг дахь чөлөөт бүсэд Татваргүй барааны дэлгүүр нээн ажиллуулахаар материалаа бүрдүүлж байсан. Гэвч Боомтын яам гэж байгуулагдаад тухайн яамнаас Чөлөөт бүс дээр Татваргүй барааны дэлгүүр ажиллуулахгүй гэсэн шийдвэрийг гаргаж Сэлэнгийн чөлөөт бүсийн бүх татваргүй барааны дэлгүүр хаагдсан, өөрөөр хэлбэл архи виски зэрэг барааг огт зарахыг хориглосон байдалтай байна.

Хувьцаа эзэмшигч Ж.Энхтунгалаг: Би ойлгохдоо энэ чиглэлийн үйл ажиллагаагаа зогсоох гэж байгаа юм байна гэж ойлгож байна.

Хурлын дарга, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаяр: 2022 оны 12 сараас эхлэн ГЕГ-ын дарга солигдсонтой холбоотойгоор Чөлөөт бүс болон Татваргүй барааны дэлгүүрүүдийн үйл ажиллагааг шалгасан. Үүнтэй холбогдуулан Чөлөөт бүс дээрх Татваргүй барааны дэлгүүрүүдийн үйл ажиллагааг зогсоож, архи, согтууруулах ундааг зарахыг хориглосон. Иймд бидний тухайн үедээ судлаж байсан чөлөөт бүсэд дэлгүүрийн салбараа нээх судалгааг зогсоосон. Бидэнд ирсэн албан тоотод няцаалт өгч хариу албан бичгийг хүргүүлсэн байгаа. Компанийн зүгээс үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор бүхий л арга хэмжээг авч ажиллаж байна. Компаниас хүргүүлсэн албан бичгүүдийг та бүгдэд танилцуулж болно.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: За. Цаашаа хэлэлцэж буй тайлбарлая.

Хувьцаа эзэмшигч нарт компанийн хэлбэр өөрчлөгдсөнөөр үзүүлэх нөлөөг 4 агуулгаар тайлбарлая. Хувьцаа эзэмшигчдэд 2 сонголт байна. Өөрийн хувьцааг компанид эргүүлэн худалдах эсвэл өөрчлөгдсөн компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх. Компанийн зүгээс шууд хувьцаа эзэмшигчдийг шахаж гаргах, эсхүл хувьцаагаа зарахыг огт тулгаагүй шүү. Бид хуулийн хүрээнд та бүхнээс компанид үлдэх эсэх талаар тодорхой хугацаанд санал авна. Эгүүлэн худалдан авах нэгж хувьцааны үнэлгээг хөндлөнгийн үнэлгээний компаниар үнэлүүлэн, тогтоолгоод ТУЗ-өөс хувьцааг эргүүлэн худалдан авах үнэлгээг тогтооно.

Ерөнхийдөө ХК-ийн хувьцаа эзэмшигч байх ХХК-ийн хувьцаа эзэмшигч байх эрх үүргийн хувьд онцын ялгаа байхгүй. Хуульд заасан эрх үүргээ эдлээд л явна гэсэн үг. Та бүхэн ХХК болох компанидаа үлдэх бүрэн боломжтой. Үүнийг СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журам, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар зохицуулсан байдаг.

Хувьцаа эзэмшигч Ж.Энхтунгалаг: Миний хувьцаа эзэмшдэг өөр нэг компани хэлбэрээ өөрчлөн ХХК болохдоо надад таны хувьцааны тоо ширхэг хөрвөхөд хүрэхгүй байх тул 200, 300 мянган төгрөг нэмж өгөөд ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр үлдэх ёстой гэсэн санал тавьж байсан. Компанид ийм асуудал байгаа юу? Хоёрдугаарт Би анх танай хувьцааг 90,000 төгрөг байхад нь авч байсан. Одоо зах зээлийн ханшаар эргүүлэн авахдаа анхны үнээрээ надаас авах юмуу? Эсвэл би алдагдлаа өөрөө хүлээх үү?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Хөндлөнгийн үнэлгээний компаниар нэгж хувьцааны үнэлгээг тогтоолгоно. Гэвч Хувьцааны үнэлгээг ТУЗ-өөс тогтоохдоо шууд үнэлгээний компанийн үнэлсэн үнэлгээгээр тогтооно гэсэн ойлголт биш юм. Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дордуулахгүй байдлаар ТУЗ-аас үнэлгээг нь тогтоож болно. Жишээ нь 100,000 гээд тогтоочих юм бол ТУЗ-өөс 101,000 110,000 мянга гэж тогтоохыг үгүйсгэхгүй. ТУЗ хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг л хамгаалах үүднээс үнэлгээг тогтооно.

Хөрөнгийн биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам” –д зааснаар ХХК болох шалгуур үзүүлэлтэд хөрөнгийн үнэлгээнд нэгж хувьцааны үнэлгээг тогтоохдоо хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг зөрчсөн байна уу, зөрчөөгүй байна уу, бодитой байна уу гэдэг хөрөнгийн бирж хийсэн дүгнэлт хамаардаг. Хөрөнгийн бирж компаниас ирүүлсэн саналыг үндэслээд СЗХ-нд хүсэлтээ өгнө.

Нөгөө талаасаа тодорхой хэмжээнд хөрөнгө оруулагч хувьцааны зах зээлд ХК ч бай ХХК ч бай тодорхой хэмжээгээр эрсдэл хүлээдэг. Жишээ нь 140000 төгрөгөөр хувьцааг авсан боловч хувьцааны үнэлгээ 70000 төгрөг болж бууран тодорхой хэмжээнд хувьцаа эзэмшигч нар ханшийн зөрүүнээс алдагдал хүлээх, эрсдэл хүлээхийг бид нар үгүйсгэхгүй. Хөрөнгийн зах зээл дээр оролцож байгаа хувьцаа эзэмшигч нар та бүхэн бид нараар хэлүүлэлтгүй хувьцааны ханшийн талаар өөрсдийн хүлээх эрсдэлийг мэдэж байгаа байх гэж бодож байна. Одоогоор нэгж хувьцааны үнэлгээ тодорхой болоогүй байгаа.

Үнэлгээний компанийг компаниас сонгон шалгаруулах үйл ажиллагаа хийгдэж байна. Монголд хувьцааны үнэлгээний компани бас ховор байдаг юм байна. Тэгээд 3 үнэлгээний байгууллага санал ирүүлсэн. Тэд нараас сонгон шалгаруулаад ТУЗ-өөс гүйцэтгэх удирдлагад гэрээ байгуул гэж үүрэг даалгавар өгөх байх. Гэрээ байгуулсны дараагаар үнэлгээний ажил нь хийгдээд тэр нэгж хувьцааны үнэ тодорхой болно.

Хувьцаа эзэмшигч А.Жавхлан: Сонгон шалгаруулалт нь дуусчихсан уу?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Үгүй. Хийгдэж байгаа. Үнийн санал аваад харьцуулалт хийгдээд явж байна. Үүний дараагаар компанийн тухай хуулийн 23, 53, 54 дүгээр зүйлүүдэд заасны дагуу ажлын гуч хоногийн дотор үнэлгээ гарсны дараа та бүхнээс компанийн хэлбэрээр өөрчлөгдөхтэй холбоотой хувьцаа эзэмшигчээр үлдэх үү

хувьцаагаа зарах уу? гэдэг саналыг асуугаад явна. Энэ талаар хэлбэр өөрчлөх төсөл дээр тодорхой дурдсан байгаа та бүхэн нухацтай сайн танилцаарай.

Үүний дараагаар компани брокерын компанитай гэрээ байгуулах, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд мөнгөө байршуулах, гэрээ байгуулах, хөрөнгийн биржид материалаа өгөх, зөвшөөрөл авах, түүний дараагаар СЗХ-нд энэ мэдээллүүдээ хүргэх гэх мэт ажлууд хугацаандаа хийгдэхээр төсөлд тусгагдсан байгаа.

Компанийн зүгээс Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн газарт гэрээ байгуулаад мөнгөө байршуулчихна. Хувьцаа эзэмшигчид маань 2 сарын хугацаанд мөнгөө татаад авбал ХК-иас гараад хэрэв дээрх хугацаанд мөнгөө татан аваагүй тохиолдолд компанийн зүгээс нэрсийн жагсаалтыг нь гаргаад бүртгээд шинээр байгуулагдах ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр үлдэнэ гэсэн үг юм.

Бид үнэлгээ хийлгэсний дараагаар Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цааны бүртгэлээс хасах хувьцаа эзэмшигчдийн хурлаа дараалан хуралдуулах нь болно.

Хувьцаа эзэмшигч Э.Амаржаргал: Биржийн арилжааг хэзээ зогсоох вэ?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: СЗХ-нд хүсэлт гаргах явцад л энэ ажиллагаа хийгдэх болов уу? Яагаад гэвэл компанийн зүгээс нэгж хувьцааны үнийг тогтоох үед нэрсийн жагсаалт гарах ёстой нэрсийн жагсаалт гарч байж тэр хүн тэдэн ширхэг хувьцаа эзэмшиж байна гэдгийг тодорхой болгон тухайн хүний компанид үлдэх үү үлдэхгүй юу гэдэг саналыг нь авахгүй бол арилжаа явагдаад, хувьцаа эзэмшигч нь солигдоод байх юм бол бид нарын ажил энэ хугацаагаар хойшлоод байгаа учраас ямарваа нэгэн байдлаар арилжааг зогсоох ажиллагаа хийгдэнэ.

Компани цаг тухайд нь Хорооноос мэдээллээ аваад зөвлөлдөөд явах учраас та бүхэн ч мөн шаардлагатай бол СЗХ-нд очиж уулзах, утсаар мэдээлэл авах эрх нь нээлттэй байгаа. Яагаад гэхээр хорооны үндсэн үйл ажиллагаа бол хувьцаа эзэмшигчийн эрхийг хамгаалах ёстой.

Хувьцаа эзэмшигч Э.Амаржаргал: Хэрэв миний хувьцааг зах зээлийн үнэлгээнээс багаар худалдаад авчихвал би гомдол гаргаж болох уу? Гомдол гаргачихвал ХХК болгох процесс саатах уу?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Монгол Улсад мөрдөгдөж буй компанийн тухай хуульд заасан эрх зүйн зохицуулалтаар 1 ширхэг хувьцаа эзэмшдэг хүн гомдол гаргана уу? Зуун ширхэг хувьцаа эзэмшдэг хүн гомдол гаргана уу? ялгаагүй тооны хязгаар байхгүй. Хувьцаа эзэмшигч л бол хувьцаа эзэмшигч учраас гомдол гаргах эрх бүрэн байгаа. Харин процессын хувьд таны гомдол үндэслэлтэй байх юм бол хороо орж ирээд шалгана, шалгаад үндэслэлгүй, ХХК болгох процесс хуулийн дагуу явж байна гэх юм бол процесс цаашаа үргэлжлээд л явна.

Хувьцаа эзэмшигч Э.Амаржаргал: Тэгэхээр нэгэнт зарлагдсан үнэ дээр нөлөөлөх боломжгүй гэсэн үг үү?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Хувьцааны үнэлгээг ТУЗ-өөс тогтооно. Харин бидний хувьд ХЭХ-аараа санал гаргаж танилцуулах боломжтой.

ХХК болгох төслийн хувьд танилцуулж дууслаа. Дараагийн асуудал бол шинээр үүсгэн байгуулагдаж буй ХХК-ийн дүрмийг танилцуулъя.

Та бүхэнд одоо танилцуулж буй компанийн дүрэм бол эцсийн байдлаар биш юм. Яагаад гэхээр СЗХ ХХК болгон өөрчлөх хүсэлтийг бүртгэж аваад албан ёсоор зөвшөөрөл гарсны дараа компанийг улсын бүртгэлд бүртгэх байгаа. Иймд энэ хугацаанд та бүхэн дүрмийн төсөл дээр санал өгөх эрх нь байгаа.

Хувьцаа эзэмшигч Э.Амаржаргал: Дүрмийн 6.10.2 дээр хувьцаа эзэмшигчид ногдох ашиг гэсэн нь хуримтлагдсан ашгаас гэж залруулагдах байх гэж бодож байна.

Ерөнхий нягтлан Б.Алтанцэцэг: Тийм, үүнийг засаж оруулъя.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Таны дүрмийн 6.8 дээр өгсөн саналын дагуу "хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ" гэснийг нь "компанид мэдэгдэнэ" болгож өөрчилсөн байгаа. За хэлэлцэх асуудал бол энэ хүрээнд өндөрлөж байна.

Өөр та бүхнээс асууж тодруулах зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигч Д.Баатаржав: Компанийн шинэчилсэн дүрэмд гол гол өөрчлөлт орж байгаа зүйлсийг нь танилцуулж өгч болох уу?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Компанийн шинэчилсэн дүрмийн гол гол чухал ач холбогдолтой заалтуудыг танилцууллаа.

Хувьцаа эзэмшигч Э.Амаржаргал: ХХК дээр заавал нэрлэсэн болон зарласан хувьцаа гаргах шаардлагатай юу? Ногдол ашиг ХХК болсны дараагаар яах вэ?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Компанийн тухай хуулийн зохицуулалт нь ХК болон ХХК-д ижил үйлчилдэг. Иймд шаардлагатай гэж үзэж байна.

Бид ногдол ашгийн бодлогоо мөн ХХК болсон хойноо гаргаад явах боломжтой.

Жил бүр ашигтай ажиллавал хувьцаа эзэмшигчдэдээ магадгүй 30,40 хувийг тараах бодлогыг мөн хэрэгжүүлэх боломжтой. Эсвэл эхний 2, 3 жилдээ олгохгүй байх уу гэдэг нь тухайн үедээ та бүхний шийдэх асуудал юм. Сая хэлсэнчлэн бодлогоор зохицуулах уу? эсвэл дүрэмдээ оруулаад явуулах уу гэдэг маань мөн та бүхний шийдэх асуудал байгаа юм.

Хувьцаа эзэмшигч Д.Баатаржав: Компанийн шийдвэрийг гаргахдаа дийлэнх олонхын саналаар шийдвэрлэх үү?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Одоогийн дүрэмд бол хуулийн дагуу дийлэнх олонхын саналаар шийдвэрлэхээр заасан байгаа.

Хувьцаа эзэмшигч Д.Баатаржав: Хуралд оролцсон хүмүүсийн саналаар шийдвэрлэдэг байх боломжтой юу?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Та бүхэн саналаа өгч болно.

Хувьцаа эзэмшигч А.Жавхлан: Бид тийм саналтай байна. Хэрхэн ашигтай ажиллах талаар өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох сонирхол их байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Саналыг хурлын протоколд тусган хүлээн авлаа. Гэвч та бүхэн энэ саналыг хуулийн дагуу хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын саналаар шийднэ гэдгийг мөн ойлгож байгаа байх.

Хувьцаа эзэмшигч Э.Амаржаргал: Цаашид ТУЗ-гүй явах уу?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Одоогийн дүрэмд ТУЗ-гүй байхаар заасан байгаа. Заавал ТУЗ-тай байхыг хуулиараа шаардаагүй байгаа. Цаашлаад ТУЗ-ийн гишүүн нь ХХК-ийн хувьд тооны хязгаарлалт байхгүй. Иймд ирээдүйд 8 хувийн хувьцаа эзэмшигч маань саналаа оруулаад ТУЗ-д орох боломжтой. Та бүхэн маань бас хуралд оролцож бидний үйл ажиллагааг дэмжиж байгааг тун талархалтайгаар хүлээн авч байна. Гэхдээ бодит байдалд манай компанийн хувьцаа эзэмшигчид маш идэвхгүй байдаг. Оролцоо жил жилийн хурал дээр болон үйл ажиллагаанд оролцдоггүйг бас дурдмаар байна

Хувьцаа эзэмшигч Д.Баатаржав: Сая санхүүгийн тайланд дурдсан 900 саяын ногдол ашгийн өглөг маань том хувьцаа эзэмшигч байна уу? эсвэл жижиг хувьцаа эзэмшигчид байна уу?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Жижиг хувьцаа эзэмшигчид байдаг. Тархалтын мэдээ авахаар Регистрийн дугаар нь гарч ирдэг өөр мэдээлэл байдаггүй асуудал байгаа. Хувьцаагаа мэдэхгүй хувьцаа эзэмшигчид хүртэл байдаг. Цаашлаад бид бүх хүмүүс рүү холбогдох шаардлага үүсэж болох юм.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Хурлын дэгийн дагуу хурлаар хэлэлцсэн асуудлууд дууслаа, хэлэлцсэн асуудлын хүрээнд тооллогын комиссоос 4 асуудлаар санал хураалт явуулна.

Саналын хуудас болон санал хураалттай холбоотой асууж тодруулах зүйл байвал нээлттэй шүү.

Хувьцаа эзэмшигч Д.Баатаржав: ХХК болгон өөрчлөх мэдээ гарах хүртэл хувьцааны ханш өсөлттэй байх байх.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Ковидын үед хувьцааны ханш нилээн бууралттай 50,000 гаруй дээр тогтож байгаад 2022 оны дунд үеэс эхлэн өсөж одоогоор 66,000 байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Тооллогын комиссоос 4 саналын дүнгээ нэгтгэн та бүхэнд танилцуулахад бэлэн болсон байна.

Хувьцаа эзэмшигч А.Жавхлан: ХХК болж байгаатай холбоотойгоор жижиг хувьцаа эзэмшигчдийн саналыг хүлээн авах, саналыг тусгах асуудлыг том хувьцаа эзэмшигчдэд уламжилж өгнө гэдэгт итгэлтэй байна. Бид бүгд нь ашиг олох зорилгоор үйл ажиллагаа явуулж байгаа учраас бие биенийгээ дэмжин, хамтдаа хөгжих боломж байна гэж харж байна.

Тооллогын комиссын дарга Б.Намуундарь: Нийт өнөөдрийн хуралд 9 хувьцаа эзэмшигч оролцсоноос 99.69% хувийн зөвшөөрсөн, 0.31%-ийн татгалзсан санал өгснөөр компанийн 2023 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг батлах батлахаар шийдвэрлэсэн байна. Саналын 2-р хуудас буюу ТУЗ-ийн 2022 санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг саналын хуудсыг 99.69% зөвшөөрч, 0.31%-ийн татгалзсан санал өгснөөр батлахаар шийдвэрлэсэн байна. Саналын 3-р хуудас буюу "Жуулчин Дюти Фрий" Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон хэлбэрийг өөрчлөхийг батлах саналын хуудсыг 99.69% зөвшөөрч, 0.31%-ийн татгалзсан санал өгснөөр батлахаар шийдвэрлэсэн байна. Саналын 4-р хуудас буюу Компанийг өөрчлөх төслийг танилцуулж, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг батлах саналын хуудсыг 99.69% зөвшөөрч, 0.31%-ийн татгалзсан санал өгснөөр батлахаар шийдвэрлэсэн байна

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ:

1. ТУЗ-ийн зөвлөлийн дүгнэлтийг батлах
2. 2023 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг батлах
3. "Жуулчин Дюти Фрий" Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон хэлбэрийг өөрчлөхийг батлах
4. Компанийг өөрчлөх төслийг танилцуулж, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг шинэчилж батлах асуудалд 99.69% зөвшөөрсөн, 0.31%-ийн татгалзсан санал өгч дэмжсэн байна.

Хурлаар хэлэлцэх асуудлын хүрээнд оруулсан 4 асуудлыг 99.69 хувь дэмжигдсэн учраас тогтоолын төслийг батлахаар шийдвэрлэсэн тул тогтоолын төслийг танилцуулан баталлаа.

Ингээд өнөөдрийн хурал өндөрлөж байна хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Хурлыг хааж үг хэлнэ үү хэмээн Ц.Отгонбаяр захирлыг урьж байна.

Хурлын дарга, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаяр: “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийнхээ ээлжит хуралд хүрэлцэн ирж оролцсон та бүхэнд баярлалаа. Та бүхний саналыг хурлын протоколд тусган ТУЗ-ийн гишүүдэд танилцуулах болно. Шаардлагатай бол бидний үйл ажиллагааг дэмжвэл бид тун таатайгаар хүлээн авах болно. Манай хувьцаа эзэмшигчид маань хэдий хувьцаа нь бага байгаа боловч идэвхтэйгээр санал бодлоо илэрхийлээд, цаашдаа ХХК болоход ч бидэнтэй хамт байхад таатай байгаагаа илэрхийлж байгаад баярлалаа. Бид аль болох хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хамгаалах талаар бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх болно. Тусгай зөвшөөрлөө аваад дэлгүүрээ ажиллуулах ерөөлийг дэвшүүлье.

Энэхүү хуралд ирж, үзэл бодол, саналаа хуваалцсан явдалд дахин талархал илэрхийлье. Компанийн хувьцаа эзэмшигчид саналаа чөлөөтэй илэрхийлснээр тухайн компани илүү үнэн бодитой зөв явдаг гэж миний хувьд үздэг. Миний зүгээс илүү хичээн ажиллах болно. Хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа.

Хурлын дарга:		Ц.Отгонбаяр
Тэмдэглэл хөтөлсөн:		
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга		Б.Бат-Эрдэнэ

2023 оны 04 сарын 14-ны өдрийн 18 цаг 10 минутад дуусав.